

Гадаад бодлого

## АМЕРИКТ ГАДААД БОДЛОГЫГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛДАГ ТУХАЙ: ТӨВЛӨРӨЛ БА АРДЧИЛАЛ

Г.Төмөрчулуун  
(дэд зөдэмтэн)

АНУ-аас тус улсад суугаа элчин сайд ноён Джозел Лейкийн урилгаар 1992 оны зун АНУ-аар сар аялж, АНУ-ын гадаад бодлого боловсруулдаг арга механизмтай танилцах завшаан надад олдсон юм. Уг аяллыг АНУ-ын Мэдээллийн агентлагаас "Олон улсын гийчдын программ"-ын хүрээнд хэрэгжүүлж, түүнд Малайз, Бруней, Шинэ Зеланд, Монгол, Шри Ланка, Египет, Тонга, Кувейт, Нигери, Йордан, Танзани, Белизээс тус бүр нэгжгээд залуу дипломат, сэтгүүлчийг урьж оролцуулжээ.

Аяллын зорилго нь Америкийн гадаад бодлогын шийдвэрийг яаж гаргадаг, гадаад бодлогыг боловсруулахад оролцдог байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулахад оршиж байв. Иймд Америкийн гадаад бодлогыг боловсруулахад чухал үүрэгтэй Конгресс, Төрийн департамент, Пентагон, Үндэсний аюулгүйн Зөвлөл зэрэг байгууллагуудаар орж, их сургуулиудын нэртэй эрдэмтэдтэй уулзаж, хэвлэл мэдээллийн байгууллага, лобби хийдэг бүлгүүд, худалдаа, санхүү-банкны тогтолцооноос гадаад бодлогод үзүүлдэг нөлөө, хандлагатай газар дээр нь танилцав.

АНУ-д байх үеэрээ үзэж харсан, сонсож мэдсэнээс үзэхэд Америкийн гадаад бодлогыг боловсруулахад оролцдог, нөлөөлдөг байгууллагуудыг төр, засгийн болон төр, засгийн бус гэсэн хоёр томоохон бүлэгт хувааж болох мэт.

Эхний бүлэгт Конгресс, Ерөнхийлөгч, департаментүүд, агентлагууд орно. Хоёр дахь хэсэгт бизнес, санхүү-банкныхан (Уолл Стрит г.м.), лобби хийдэг бүлгүүд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн санаа бодол зэрэг ордог байна.

Америкийн үндсэн хуулийг зохисгчид төрийн тогтолцооны хүрээнд засгаламын тэнцвэрийг хангахад ихээхэн анхаарчээ. Энэ нь гадаад бодлогод ч мөн хамаатай ажгуу.

\* Энэ үг олон утгатай. Энэ өгүүлэлд орж байгаа утга нь гэвэл: Ямар нэг хуулийн төслийг нэвштэй шийдвэрлүүлэх үүднээс Парламент буюу их хурлын гишүүдийг "үнэмшүүлэн ятгаж" талдаа оруулах хүмүүсийн бүлэг болно.

## Гадаад бодлого ба Конгресс

Үндсэн хуулинд заасны дагуу болон уламжлал ёсоор АНУ-ын Конгресс Америкийн нийгмийн дотоод асуудалд голлон анхаардаг авч гадаад бодлогыг томъёолоход 5 үндсэн хэлбэрээр оролцдог байна. Үүнд: Гадаад арга хэмжээнд ( эдийн засгийн тусламж, зээл, худалдааны нэн таатай нөхцөл олгох, цэргийн тусламж үзүүлэх, зэвсэг худалдах, гадаадад суугаа ЭСЯ-дыг сайнхүүжүүлэх г. м) зориулах төсвийг батална. Хоёрдугаарт, АНУ-ын засаг захиргаанаас гадаад орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрийг Конгрессын гишүүдийн гуравны хоёрын саналаар батална. Гуравдугаарт, АНУ-ын төрийн сайд нар, элчин сайд нарыг батална. Дөрөвдүгээрт АНУ-ын гадаад дахь үйл ажиллагаа, тодорхой бүс нутгийн байдал, америкийн гадаад болон аюулгүй байдлын бодлогын асуудлаарх засаг захиргааны тайланг хэлэлцэж санал дүгнэлт гаргаж, ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж байдаг. Тавдугаарт, Конгресс дайн зарлах эрхтэй.

АНУ-ын гадаад бодлогын асуудлаар зөвлөмж гаргах, хяналт тавих, үнэлэлт өгөх, үүргийг Сенатад Гадаад харилцааны хороо; Төлөөлөгчдийн танхимд Гадаад хэргийн хороо; Зэвсэгт хүчний хоёр хороо; Тусгай албадын хоёр хороо хүлээдэг байна. Эдгээрийн дотроос санхүүжилтийн хороод ялангуяа, дэд хороод хөрөнгө мөнгө баталдаг утгаараа, гадаад хэргийн хороод нь бодлого баталдаг утгаараа голлох үүрэгтэй байдаг ажээ.

## Гадаад бодлого ба Ерөнхийлөгч

Гадаад бодлогын асуудлаар АНУ-ын ерөнхийлөгч хоёр том эрх эдэлдэг. Нэгдүгээрт ерөнхийлөгч үндсэн хуулийн дагуу бүх цэргийн ерөнхий командлагч байдаг. Энэ дагуу тэр Америкийн цэргийг хаашаа ч илгээж, яаж байршуулах бүрэн эрхтэй. Чухамдаа ерөнхийлөгчийн шийдвэрээр энэ оны эхээр Иракт холбоотнууд хэд хэдэн удаа цохилт өгчээ. Хоёрдугаарт ерөнхийлөгч өдөр тутмын дипломат бодлогыг эрхлэн явуулагч юм. Энэ нь бусад оронтой хэлэлцээ хийж, гэрээ, хэлэлцээр байгуулах, элчин сайд нарыг томилох гэх зэрэг эрх эдэлдэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл гадаад бодлогод Конгрессын үүрэг нөлөө байдаг ч АНУ-ын ерөнхийлөгч голлох үүрэгтэй байна.

Ерөнхийлөгчийн бодлогыг департаментууд, агентлагууд хэрэгжүүлдэг. Гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчид зөвлөлгөө өгдөг гол байгууллага-Төрийн департаментийн үндсэн үүрэг нь АНУ-ын аюулгүй байдал, хангалуун амьдралын урт хугацааны зорилтыг хангах явдал ажээ. Төрийн департамент нь гадаад дахь Америкийн ашиг сонирхолд холбогдох үйл явдалд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж гаргах, авах арга хэмжээний тухай санал боловсруулах, нэгэнт тодорхойлогдсон бодлогыг хэрэгжүүлэх үүднээс холбогдох дипломат алхам хийж байдаг. Төрийн департаментууд агентлагууд, гадаад улсуудын засгийн газартай байнга зөвлөлдөж байдаг. Тэрээр гадаад улс орнуудтай хэлэлцээ

хийж, НҮБ болон 50 гаруй олон улсын байгууллагад АНУ-ыг төлөөлж, жил бүр 800 гаруй олон улсын бага хуралд оролцож, 170 улсад суугаа АНУ-ын элчин сайдын яамдын ажлыг удирдаж заавар зөвлөлгөөгөөр хангаж байдаг аж. Төрийн департамент 25, 500 хүнтэй. Гэвч энэ нь 2,2 сая хүнтэй Пентагоныг бодвол хамаагүй бага тоо гэж төрийн департаментынхэн ярьж байв.

Төрийн департаментын зэрэгцээ Батлан хамгаалах яам улс орны аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл аюулгүй байдлын асуудлаарх дотоод, гадаад бодлогын нэгдлийг хангах үүднээс ерөнхийлөгчид зөвлөмж өгөх, мэдээллийн агентлаг нь гадаад бодлогыг мэдээлэл, сурталчилгааны талаас нь хангах үүрэгтэй. Эдгээр байгууллагууд цөм Ерөнхийлөгчийн удирдлага дор ажлаа явуулдаг.

Гадаад бодлогын асуудлаар Конгресс, засаг захиргаа хоёрын хооронд ажлын нарийн хуваарь байна гэсэн сэтгэгдэл төрж байв. Жишээ нь Ерөнхийлөгч гадаад бодлогын асуудлаар санал гаргаж, түүнийг нь Конгресс хэлэлцэж батлаж, нэгэнт батлагдсан арга хэмжээг Ерөнхийлөгч хэрэгжүүлж, түүний эцсийн дүнг Конгресс үнэлж дүгнэнэ.

АНУ-ын Конгрессын номын санд болсон ярилцлагын үеэр гадаад бодлогод Конгрессулам бүр идэвхтэй орох болсон тухай ярьж байлаа. Үүнийг АНУ-ын Конгресс дурдсан 4 шатны аль алинд нь оролцох болж байгаагаар Конгрессын мэргэжилтнүүд тайлбарлаж байв.

Конгресс, Ерөнхийлөгч хоёр гадаад бодлогын асуудлаар санал зөрөх нь энүүхэнд аж. Ийм зөрөлдөөний тодорхой жишээ хуучин Ерөнхийлөгч Бушийн БНХАУ-ын талаарх бодлого байв. Сүүлд явагдсан сонгуулийн дүнд Конгрессийн бүрэлдэхүүн ихээхэн өөрчлөгдөж түүнд ардчилсан намынхан давамгайлах болсон тул дээрх маягийн зөрөлдөөн Конгресс, ерөнхийлөгч Клинтон хоёрын хооронд гарахгүй байх аа гэж АНУ-ын Конгресс үзэж байна.

Конгресст зочлох үеэр нэг сонин мэдээ олж сонсов. Биднийг хүлээн авч уулзсан Конгрессын нэг салбар хорооны дарга Монголын сонгуулийн дүнд их санаа зовж байна гээд (Бид 6 дугаар сарын 24-нд уулзсан) Монголын сонгуулийг нэг их гүрэн хянаж, өөртөө ашигтай үр дүн гаргуулж мэдэхээр байгаа тухай мэдээг бид авлаа гэж тэр хэлэв. Үүнийг сонсоод тун ч нарийн мэдээлэлтэй улс юм даа гэсэн бодол өөрийн эрхгүй төрж байлаа. Манай улсын их хурлын гишүүд гадаад бодлогын асуудлаар ийм мэдээлэлтэй байдагсан бол улсад мөн ч их хэрэгтэйсэн.

Америкийн гадаад бодлогын шийдвэрт Конгресс, Ерөнхийлөгч голлох үүрэгтэй боловч тэр шийдвэрт нөлөөлөх бусад олон хүчин зүйл байдаг ажээ. Тэдний дотроос лобби эрхэлсэн бүлгүүд, хэвлэл мэдээллийн үүргийг товч ашиг үзье.

## Гадаад бодлого ба Лобби

Гадаад бодлогонд лобби ямар үүрэгтэйг ойлгуулах үүднээс биднийг Вашингтонд байдаг Нийл энд компани хэмээх зуучлах байгууллагын үйл ажиллагаатай танилцуулав. Тэнд бидэнд тайлбарлахдаа АНУ-д ийм байгууллага 10,000 байдаг бөгөөд тэдний үйл ажиллагаа америкийн олон нийтийн санал бодол, Конгресс, Ерөнхийлөгчийн шийдвэрт нөлөөлөхөд чиглэдэг гэж байв. Лобби бол Америкийн нийгмийн улс төрийн амьдралын салшгүй хэсэг гэнэ. Израилийн лобби АНУ дахь хүчтэй лоббийн нэг гэнэ. Тэд жишээ нь Оросоос Израилд ирж буй өөрөйчүүдийг суурьшуулахад зориулан барих орон сууцанд 10млрд америк долларыг Конгрессээс өнгөрсөнд гаргуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна.

Нийл энд компани зуучлагч байгууллага нь Пакистан, Кувейт, Египет зэрэг гол төлөв хөгжиж байгаа орнуудын эрх ашгийн төлөө лобби хийдэг ажээ. Чингэхдээ үйл ажиллагаагаа хоёр чиглэлээр явуулдаг гэнэ. Үүнд, Жишээ нь Египетийн эрх ашгийг шууд хөндөхөөр Америкийн хууль тогтоох байгууллагын шийдвэрийн тухай Египетийн талд мэдээлэх; Конгресс болон Засгийн газартай тогтоосон ажлын холбоондоо түшиглэн Египетийн эрх ашгийг хамгаалах. Дашрамд АНУ-аас Египетэд үзүүлж буй цэргийн тусламжийг нэмэгдүүлэхэд дээрх компани багагүй хүч чармайлт гаргажээ.

Санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны тухайд гэвэл Нийл энд компани өөрийн түнш улсынхаа ер төлбөрийг барагдуулах, энэ асуудлаар хэлэлцээ хийхэд тэдэнд зөвлөмж өгдөг байна. Олон улсын хөгжлийн агентлаг, Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг байгуулагатай хэрхэн ажиллах, тэднээс түнш улсад үзүүлэх тусламжийг нэмэгдүүлэх талаар зөвлөлгөө өгнө. Дээрх компанийн бас нэг чухал зорилго нь АНУ-ын Засгийн газрын болон хувийн секторын түнш оронд хөрөнгө оруулах явдлыг дэмжихэд оршдог байна.

### Хэвлэл мэдээлэл

Хэвлэл мэдээллийг дөрөв дэхь засаглал гэж ярьдаг.

Монголд ийм байна гэж хэлэхэд хэцүү бололтой. Харин АНУ-ын хувьд хэвлэл мэдээлэл 4 дэхь засаглал гэдэг нь тун тодорхой аж. АНУ-д хэвлэлээр дамжуулж ерөнхийлөгчийг огцруулж болдог. (Уотергейт), өөр улсуудтай дайн хийж болдог (Иракийн эхр дэгл), Хэвлэл хар юмыг цагаан, цагаан юмыг хар болгож чадна. Биднийг Вашингтон Пост сонин тэнгэрт тулсан өндөр байшин дахь түүний редакцтай уулзахад ийн ярьж байв. Америкт өдөр бүр 17000 сонин 63 сая хувиар хэвлэгдэж, 8000 радиостанц ажиллаж, 45000 нэр төрлийн ном хэвлэгдэж байдаг. Гэхдээ хамгийн гол нь тонд бус чанарт байдаг гэнэ. Ерөөс америкчуудын нэг онцлог нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлдээ их цтгэдэг

явдал юм. Энэ нь Вашингтон Пост, Нью-Йорк Таймс зэрэг нэр хүндтэй томоохон сонинууд, Си-Эн-Эн зэрэг телевизийн нэвтрүүлгийн хувьд ч бүр ч үнэн. Хоёр жишээ хэлье. Өнгөрсөн онд манайд болсон сонгуулийн өмнө Монголын тухай америкчуудын ойлголт туйлын нааштай байлаа. Энэ нь биднийг дагалдаж явсан америк хүмүүсийн хэлсэн, ярьсан зүйлээс илт мэдэгдэж байв. Гэтэл сонгуулийн дараа Бээжинд суугаа Нью-Йорк Таймс сонин сурвалжлагч Николас Кристофийн хэд хэдэн өгүүлэл гарсны дараа Монголын тухай америкчуудын төсөөлөлд ихээхэн өөрчлөлт оржээ гэсэн сэтгэгдэл надад төрсөн. Николас Кристоф нэг өгүүлээ "Өөрийн хойд эх Орост гологдсон Монгол Ардчилалд дахиад гологдов" гэж гарчиглажээ. (Нью-Йорк Таймс 1992.07.05) Америкийн урдаа барьдаг сэтгүүлчдийн нэг болох Кристофийн үгэнд итгэдэггүй төрийн байгууллага, хувь хүн америкт тун цөөхөн шүү гэж биднийг дагалдаж явсан нэг америк хүн ярьж билээ.

Хуучин ЗХУ-д гарсан төрийн эргэлт хийх оролдлого, 1989 онд Тяньаньмэний талбайд болсон оюутны жагсаал, Иракийн эсрэг холбоотнуудын дайны үеийн Бушийн гадаад бодлогын үйл ажиллагаа нь Си-Эн-эн телевизийн сувгаар цацсан мэдээнд тулгуурлаж байжээ. Тагнуулын төв газрын мэдээ гадаад орнууд дахь тухайлбал Москва, Бээжин, Багдад дахь Америкийн ЭСЯ-ны төвдөө өгч байгаа мэдээнүүд дээрх СНН-ийн нэвтрүүлэгтэй харьцуулахад бараг хэрэгцээгүй байсан гэдэг.

Эл хоёр баримт АНУ-ын гадаад бодлогод хэвлэл мэдээллийн үүрэг хичнээн ихийг харуулах тодорхой жишээ юм.

Америкийн гадаад бодлогод хэн эцсийн үгээ хэлдэг вэ гэвэл мэдээж ерөнхийлөгч гэсэн ганцхан үгээр хариулна. Гэхдээ л гадаад бодлогын эцсийн шийдвэр төр, засгийн төв байгууллагууд, муж улсууд, сенатчид, конгрессын гишүүд бизнесмөнүүд, банкны эзэд лоббистууд, хэвлэл мэдээллийнхэн, олон нийтийн санаа бодол гэх зэрэг олон арван элемент, хүчин зүйлийн зохицол, зөвшилийн үр дүн байдаг аж. Энэ утгаараа гадаад бодлогын шийдвэр гаргах америк маягийн үйл явц нь наанаа Ерөнхийлөгчид хэт төвлөрсөн мэт харагдавч цаанаа олон хүчин зүйлийг харгалзаж байдгаараа гүнзгий ардчилсан шинжтэй ажгуу.